

2019.11.14

## ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХОРОГДУУЛАХ ШИНЭЭР ХУВЬЦАА ГАРГАХ, ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ

/төсөл/

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, зөвшөөрөл олгохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1.Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн иргэний хувьд татвар төлсний дараах орлого, хуулийн этгээдийн хувьд жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, татварын тайлангаар баталгаажсан хуримтлагдсан ашиг болон хөрөнгө борлуулсны орлого байна.

2.2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулна:

2.1.1.тухайн банк бус санхүүгийн байгууллагын тайлант жилийн ашгаас хувьцаа эзэмшигчид хуваарилсан татвар төлсний дараах ногдол ашгаар;

2.1.2.хувьцаа эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн татварын тайлан, татвар төлсний дараах хууль ёсны орлого;

2.1.3.шинээр хувьцаа гаргах;

2.1.4.хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа гэр бүлийн гишүүд, өөрийн төрсөн ах дүү, эхнэр, нөхөр, хүүхдүүдэд бэлэглэх, өвлүүлэх, эсхүл хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдэд худалдах;

2.1.5.Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

2.2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүсч, хүсэлт гаргаж буй ББСБ нь өргөдөл, баримт бичгээ Хорооны бичиг хэрэгт бүртгүүлсэн өдрөөс хойш хүсэлтийг хянаж, Хорооны дарга шийдвэрлэх хүртэлх хугацаанд хувь нийлүүлэх мөнгөн хөрөнгийг байршуулсан данснаас зарлагын гүйлгээ хийхдээ нэмэгдүүлэх зөвшөөрөл хүссэн хувь нийлүүлсэн хөрөнгийг бууруулсан гүйлгээ хийхийг хориглоно.

2.3.Хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлэхээс 3 өдрийн өмнө хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны тодорхойлолт, дансны хуулгыг Хороонд ирүүлэх ба холбогдох ажилтан энэ журмын 2.2 дахь заалтын хэрэгжилтийг шалган баталгаажуулсан байна.

### ГУРАВ. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

3.1.Банк бус санхүүгийн байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтээ энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан өргөдлийн маягтын дагуу гаргаж, 2 дугаар хавсралтад заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд бичгээр болон цахимаар ирүүлнэ.

3.2.Зөвшөөрөл хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан тохиолдолд Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

3.3.Хорооны бичиг хэрэгт хүлээн авч, бүртгүүлсэн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн дотор Хорооноос хянаж, Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

3.4.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу ББСБ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр Хорооны даргын шийдвэрийг үндэслэн холбогдох гүйлгээг хийнэ.

3.5.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа ББСБ нь Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

3.6.ББСБ нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл эх хувийг Хороонд ирүүлнэ.

### ДӨРӨВ. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХООС ТАТГАЛЗАХ

4.1.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр олгохоос татгалзана:

4.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгө нь хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдоогүй;

4.1.2.энэхүү журмын 2.2 дахь заалтыг зөрчиж хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх мөнгөн хөрөнгөөс зарлагын гүйлгээ хийсэн;

4.1.3.хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ хэлцэл хуурамч болох нь нотлогдсон.

4.2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчид Хорооны асуудал хариуцсан газрын даргын албан бичгээр мэдэгдэнэ.